

МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/373

Мандалговь

Журам батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "г", Орон сууцны тухай хуулийн 8.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын өмчлөлд байгаа орон сууцыг ашиглах, эзэмших журмыг хавсралтаар баталсугай.

2. Тус журмыг мөрдөн, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат)-д даалгасугай.

3. Энэ захирамжийг баталсантай холбогдуулан аймгийн Засаг даргын "Журам батлах тухай" 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/361 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210480

Дундговь аймгийн Засаг даргын
2021 оны 10 сарын 12-ний өдрийн
0/172 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ОРОН СУУЦЫГ АШИГЛАХ, ЭЗЭМШИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү “Орон сууц ашиглах, эзэмших журам”-аар аймгийн Засаг даргын Тамгын газрын өмчлөлд байгаа орон сууцыг Тамгын газрын болон бусад төрийн албан хаагчдад ажиллах хугацаанд нь эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Орон сууц эзэмшүүлэхдээ Монгол Улсын Иргэний хуулийн 310 дугаар зүйл, энэхүү журмыг удирдлага болгон сууц эзэмшигчтэй гэрээ байгуулна.

1.3. Орон сууцны түрээсийн төлбөрийн хэмжээг тооцохдоо аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 71 дүгээр тогтоолыг үндэслэнэ.

1.4. Энэхүү журмыг өмчлөгч, эзэмшигч талууд дагаж мөрдөнө.

Хоёр.Засаг даргын Тамгын газрын үүрэг

2.1. Орон сууцыг эзэмшигчдийн эзэмшилд шилжүүлэхэд бэлэн болгосон байна.

2.2. Орон сууцны цэвэр, бохир усны хоолой, угаалтуур, крант, хаалт болон цахилгаан шугам сүлжээ, монтажийг зохих хэмжээнд хүлээлгэн өгөх

2.3. Орон сууцны зохистой ашиглалтыг хангуулах, хэрэглээний зардал болон түрээсийн төлбөр төлөгдөөгүй тохиолдолд түүнийг төлөхийг шаардах

2.4. Орон сууцны эзэмшигч бүртэй аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Түрээсийн гэрээний журам батлах тухай” 08 дугаар тогтоолын дагуу гэрээ байгуулна.

2.5. Орон сууцыг хүлээлгэн өгөх, хүлээж авахдаа ажлын хэсэг томилж, акт үйлдэж, гарын үсэг зуруулна.

2.6. Орон сууцыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар хуваарилна.

2.7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын өмчлөлд байгаа 12 айлын орон сууцыг 4 жил, Говийн тэнгэрийн буюу 17 А байранд 3 жилийн хугацаагаар түрээслүүлэх

2.8. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 222 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газрын өмчлөлд байгаа орон сууцыг хувьчилж үл болох жагсаалтанд оруулсан тул хувьчлах асуудлыг хүлээн авахгүй.

2.9. Орон сууц түрээслэгч төлбөрийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутам гэрээнд заасны дагуу алданги тооцох ба 6 сараас дээш түрээсийн төлбөрийг төлөөгүй тохиолдолд гэрээний үүргээ биелүүлээгүйд тооцож албадан гаргах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дундговь аймгийн Засаг даргын
2021 оны 10 сарын 13 ний өдрийн
А/373 дугаар захирамжийн хавсралт

Гурав.Эзэмшигчийн эрх, үүрэг

- 3.1. Эзэмшигч нь гэрээний дагуу орон сууцыг зөв зохистой ашиглах
- 3.2. Орон сууцыг ашиглаж, эзэмшихдээ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан 1м.кв талбайн түрээсийн жишиг үнийн дагуу түрээслэж байгаа орон сууцны төлбөрийг сар бүрийн 25-ны өдрийн дотор төлөх
- 3.3. Эзэмшигч нь гэрээнд заасны дагуу төлбөрийг сар бүр төлж байх
- 3.4. Хэрэв эзэмшигч төлбөрийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутам гэрээнд заасны дагуу алданги төлнө.
- 3.5. Эзэмшигч нь орон сууц эзэмших эрхийг Засаг даргын Тамгын газрын даргын шийдвэргүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- 3.6. Эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр орон сууцанд нэмэлт засвар үйлчилгээ хийх тохиолдолд гарах зардлыг өөрөө хариуцна.
- 3.7. Орон сууцны нэгдсэн байранд эзэмшигчдийн тав тухтай байдлыг хангах үүднээс байрны даргыг олонхийн саналаар томилж, дарга нь ашиглалт, эзэмшилд байнгын хяналт тавьж ажиллана.
- 3.8. Эзэмшигч нь өндөр насны тэтгэвэрт гарсан, чөлөөлөгдсөн болон халагдсан тохиолдолд 30 хоногийн дотор орон сууцаа хүлээлгэн өгнө.

Дөрөв.Талуудын хүлээх хариуцлага

- 4.1. Хэрвээ талууд энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд буруутай тал нь түүнээс үүдэн гарсан хохирлыг санхүүгийн нотлох баримтыг үндэслэн барагдуулна.
- 4.2. Талуудын байгуулсан орон сууц ашиглах, эзэмших гэрээг хэрэгжүүлэх явцад ямар нэгэн маргаан гарвал талууд аль аль талдаа сэтгэл ханамжтай байх шийдлийг олохын тулд бие биеэ харилцан хүндэтгэж, хэлэлцээрийн журмаар шийдвэрлэнэ.
- 4.3. Хэрэв талууд тохиролцож чадахгүйд хүрвэл Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР